

Төсөл

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

..... оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ЖИШИГ ҮНЭ ТОГТООХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, Үндэсний аудитын газрын саналыг үндэслэн ТУШААХ нь:

1. Төсвийн байгууллага, Монгол Улсын Засгийн газраас санхүүжиж байгаа төслийн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөрийн хэмжээг нэгдүгээр хавсралтаар, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөрийн жишиг үнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, мөрдсүгэй.

2. Төсвийн байгууллага, Монгол Улсын Засгийн газраас санхүүжиж байгаа төсөл, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгжийн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээ үзүүлэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулан ажилласугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын 2018 оны "Аудитын үйлчилгээний төлбөрийн жишиг үнэ тогтоох тухай" 251 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т даалгасугай.

САЙД

Б.ЖАВХЛАН

Сангийн сайдын 2022 оны дугаар сарын-ны
өдрийн дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС
САНХҮҮЖИЖ БАЙГАА ТӨСЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Төгрөгөөр

Д/д	Аудитын үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтооход харгалзах үзүүлэлт	Аудитын багийн ажлын нэг цагийн төлбөрийн хэмжээ
1	Нийт хөрөнгийн хэмжээ эсвэл үндсэн үйл ажиллагааны зардал 500.0 сая төгрөг хүртэл	13,500.00
2	Нийт хөрөнгийн хэмжээ эсвэл үндсэн үйл ажиллагааны зардал 500.0-1,500.00 сая төгрөг хүртэл	18,000.00
3	Нийт хөрөнгийн хэмжээ эсвэл үндсэн үйл ажиллагааны зардал 1,500.00 -5,000.0 сая төгрөг хүртэл	25,200.00
4	Нийт хөрөнгийн хэмжээ эсвэл үндсэн үйл ажиллагааны зардал 5,000.00-10,000.00 сая төгрөг хүртэл	36,500.00
5	Нийт хөрөнгийн хэмжээ эсвэл үндсэн үйл ажиллагааны зардал 10,000.00 сая төгрөг хүртэл	47,500.00

Тайлбар:

1.Аудитын багийн ажлын нэг цагийн төлбөрийн хэмжээний ангиллыг тооцохдоо нийт хөрөнгө, үндсэн үйл ажиллагааны зардлын аль ихийг харгалзан үзнэ.

2.Аудитын үйлчилгээ үзүүлэх хугацааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу сонгон шалгаруулсан гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд тусган ажиллана.

3.Олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгжийн аудитын үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоохдоо батлагдсан төсвийг нь үндэслэн тухай бүр гэрээгээр зохицуулна.

Сангийн сайдын 2022 оны дугаар сарын-ны
өдрийн дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ТЭДГЭЭРИЙН
ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ЖИШИГ ҮНЭ**

Төгрөгөөр		
Д/д	Аудитын үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтооход харгалзах үзүүлэлт	Аудитын багийн ажлын нэг цагийн төлбөрийн хэмжээ
1	Нийт хөрөнгийн хэмжээ эсвэл борлуулалтын орлого 500.0 сая төгрөг хүртэл	24,500.00
2	Нийт хөрөнгийн хэмжээ эсвэл борлуулалтын орлого 500.0-3,000.0 сая төгрөг хүртэл	37,500.00
3	Нийт хөрөнгийн хэмжээ эсвэл борлуулалтын орлого 3,000.0-10,000.00 сая төгрөг хүртэл	52,500.00
4	Нийт хөрөнгийн хэмжээ эсвэл борлуулалтын орлого 10,000.00-40,000.00 сая төгрөг хүртэл	67,500.00
5	Нийт хөрөнгийн хэмжээ эсвэл борлуулалтын орлого 40,000.00-100,000.00 сая төгрөг хүртэл	82,500.00
6	Нийт хөрөнгийн хэмжээ эсвэл борлуулалтын орлого 100,000.0 сая төгрөгөөс дээш	110,000.00

Тайлбар:

1.Аудитын багийн ажлын нэг цагийн төлбөрийн хэмжээний ангиллыг тооцохдоо нийт хөрөнгө, борлуулалтын орлогын аль ихийг харгалзан үзнэ.

2.Аудитын үйлчилгээ үзүүлэх хугацааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн сонгон шалгаруулсан гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд тусган ажиллана.